

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

---

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН  
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ  
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

1. Нэгдсэн танилцуулга
2. Тооцоо, судалгаанууд
3. Шалгалтын дүнг хэлэлцсэн хурлын тэмдэглэл

Ажлын хэсэгт :

|                             |             |
|-----------------------------|-------------|
| Санхүүгийн хяналт шалгалтын |             |
| улсын ахлах байцаагч        | А.Ариунбаяр |
| улсын байцаагч              | С.Намшир    |

Эхэлсэн хугацаа : 2025.01.23  
Дууссан хугацаа : 2025.01.24

2025 он



ТӨВ АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 33/63

Зуунмод

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ОНХС-ИЙН  
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ

**Нэг. Хяналт шалгалтын зорилго**

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”, “Төсвийн тухай хууль”-уудын хүрээнд Төв аймгийн Баянцогт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Монгол улсын “Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журам, норм нормативын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөхөд шалгалтын зорилго оршино.

**Хоёр. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа**

Шалгалтыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Дотоод аудитын хорооны даргын баталсан 33/63 тоот удирдамжийн дагуу Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч А.Ариунбаяр ахлан санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч С.Намшир нь Баянцогт сумын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрөөс эхлэн ажлын 1 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

**Гурав. Хамрагдсан асуудал**

Шалгалтыг тус сумын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны холбогдох баримтанд тулгуурлан шалгаж үнэлэлт дүгнэлт өгснөөс гадна дараах чиглэлээр тодотгож хийсэн. Үүнд:

- Төсвөөс олгогдсон санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалт, үр ашиг
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн тайлан мэдээ гаргалтын байдал
- Худалдан авах үйл ажиллагаа, тендер зохион байгуулалт

- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын ашиглалт, хамгаалалт, хөрөнгөд бүртгэсэн эсэх
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг дагаж мөрдөж буй эсэхийг тус тус хамруулан шалгалаа.

#### **Дөрөв. Шалгалтад хамрагдсан объектын талаар товч мэдээлэл**

Шалгалтад хамрагдсан хугацаанд Төсвийн Ерөнхийлөн захирагчаар Б.Баттүшиг, Санхүүгийн албаны даргаар Б.Долгорсүрэн нар ажиллаж хөрөнгийг захиран зарцуулах, хамгаалах үүрэг, хариуцлагыг хүлээн ажиллажээ.

#### **Тав. “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хувьд 2024 онд:**

Засгийн газрын ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлалын дагуу 2024 онд Баянцогт суманд итгэлцүүрээр хувиарлагдсан 359,713.6 мянган төгрөг, сумын ОНХС-ын шилжих үлдэгдэл 54,009.0 мянган төгрөг, малын хөлийн татвараас 25,000.0 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 20,000.0 мянган төгрөг, нийт эх үүсвэрийг 454,722.6 мянган төгрөгөөр эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

Тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор ОНХСангийн орлогын хэмжээ 448,014.3 мянган төгрөгөөр батлагдсан.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор ОНХСангийн орлогын хэмжээ 354,722.6 мянган төгрөг, тэдгээрээр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтаар 454,722.6 мянган төгрөгөөр тодотгон батлуулсан.

#### **Орлого эх үүсвэр:**

| № | Орлогын шилжүүлгийн төрөл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл        |
|---|---------------------------|-----------------------|------------------|
| 1 | Оны эхний үлдэгдэл        | 50,009.0              | 37,566.3         |
| 2 | Тайлант оны санхүүжилт    | 359,713.6             | 350,253.3        |
| 3 | Малын хөлийн татвар       | 25,000.0              | 31,708.3         |
| 4 | Хандив                    | 20,000.0              | 5,370.5          |
|   | <b>НИЙТ ДҮН</b>           | <b>454,722.6</b>      | <b>424,898.4</b> |

#### **Хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ**

| № | Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ | Батлагдсан төлөвлөгөө | Тодотгосон төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|------------------------------------------------|-----------------------|-----------------------|-----------|
|---|------------------------------------------------|-----------------------|-----------------------|-----------|

|                             |                                                     |                  |                  |                  |
|-----------------------------|-----------------------------------------------------|------------------|------------------|------------------|
| <b>Он дамнасан ажлууд:</b>  |                                                     | <b>31,007.2</b>  | <b>31,007.2</b>  | <b>25,543.6</b>  |
| 1                           | Үйлдвэр хороололд тоглоомын талбай                  | 26,007.2         | 26,007.2         | 25,543.6         |
| 2                           | Зураг төсөв /Дулаан, спорт заал, цэцэрлэг гм/       | 5,000.0          | 5,000.0          | -                |
| <b>Шинээр эхлэх ажлууд:</b> |                                                     | <b>417,007.1</b> | <b>423,715.4</b> | <b>338,941.5</b> |
| 3                           | Зараагийн дэнж хогийн цэг түрж хашаажуулах          | 10,000.0         | 10,000.0         | 4,000.0          |
| 4                           | Спорт заалны шал солих                              | 100,000.0        | 100,000.0        | 64,712.6         |
| 5                           | Ундны усны худаг цахимжуулах, засвар үйлчилгээ      | 14,000.0         | 14,000.0         | 13,958.0         |
| 6                           | Дунд-Урт голын гүүр засварлах                       | 7,000.0          | 7,000.0          | 6,998.0          |
| 7                           | 12 айлын дээвэр засвар, гадна фасат                 | 59,400.0         | 59,400.0         | 57,210.5         |
| 8                           | Даргиат 3-р баг камержуулалт хийх                   | 20,000.0         | 20,000.0         | 19,987.0         |
| 9                           | Сарлаг багийн цэцэрлэгийн байрны засвар             | 30,000.0         | 30,000.0         | 28,751.2         |
| 10                          | Гамшигаас хамгаалах зардал                          | 14,607.1         | 14,607.1         | 8,734.2          |
| 11                          | Соёлын төвийн өргөтгөлийн засвар                    | 15,000.0         | 15,000.0         | 15,000.0         |
| 12                          | Нохой муур устгах                                   | 2,000.0          | 2,000.0          | 2,000.0          |
| 13                          | ЗДТГ-ын барилгын засвар                             | 100,000.0        | 100,000.0        | 98,275.3         |
| 14                          | Даргиат 3-р багт бод малын тарилгын хашаа барих     | 9,000.0          | 9,000.0          | -                |
| 15                          | Гуна баг хар үзүүрийн хадлангийн талбай хашаажуулах | 10,000.0         | 10,000.0         | 10,000.0         |
| 16                          | Мал хамгаалах гамшигийн зардал                      | 6,000.0          | 12,708.3         | 5,814.8          |
| 17                          | Наадам, ахмадын баяр гм арга хэмжээний зардал       | 20,000.0         | 20,000.0         | 3,500.0          |
| <b>НИЙТ ДҮН</b>             |                                                     | <b>448,014.3</b> | <b>454,722.6</b> | <b>364,485.1</b> |

**ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт:**

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтад заагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 5-д зааснаар “Баг, хорооны Засаг дарга нь сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд ОНХС-ийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг дараагийн төсвийн жилийн аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний танилцуулгын хамт бэлтгэж баг, хороо, сум, дүүргийн мэдээ, мэдээллийн хэрэгслээр дамжуулан жил бүрийн 2 дугаар сард багтаан олон нийтэд танилцуулна” гэж заасны дагуу багийн иргэдэд БИНХурлын хуралдаанд мэдээлэл хийсэн баримтжуулсан байна.

Багийн Засаг дарга нар иргэдээс саналын хуудас, бүлгийн ярилцлага, болон цахим хэлбэрийн аль нэгээр санал авсан байдал иргэдийн оролцоо

| Багийн нэр      | Өрхийн тоо | Иргэдийн тоо | Санал асуулгын хуудсаар санал өгсөн өрхийн тоо | Цахимаар санал өгсөн иргэдийн тоо | Өрхийн оролцоо хувиар |
|-----------------|------------|--------------|------------------------------------------------|-----------------------------------|-----------------------|
| Гуна 1-р баг    | 222        | 475          | 83                                             | 0                                 | 37.4                  |
| Сарлаг 2-р баг  | 215        | 511          | 77                                             | 0                                 | 35.8                  |
| Даргиат 3-р баг | 325        | 931          | 91                                             | 13                                | 32.0                  |
| Нийт дүн        | 762        | 1917         | 251                                            | 13                                | 34.6                  |

Багийн иргэдийн нийтийн хурлаар иргэдийн гаргасан саналыг эрэмбэлж 6 дугаар сард багтаан хийж тогтоол гаргасан байдал: Гуна баг 2023 оны 06 сарын 02-ны өдрийн БИНХ-ын 01 тоот тогтоолоор, Сарлаг баг 2023 оны 06 сарын 29-ний өдрийн БИНХ-ын 01 тоот тогтоолоор, Даргиат баг 2023 оны 07 сарын 01-ний өдрийн БИНХ-ын 01 тоот тогтоолоор тус тус баталж хэрэгжүүлсэн байна.

| №  | Төслийн нэр                                         | Гуна 1-р баг | Сарлаг 2-р баг | Даргиат 3-р баг | Багаас гарсан саналын тоо | Ажлын хэсгийн эрэмбэ |
|----|-----------------------------------------------------|--------------|----------------|-----------------|---------------------------|----------------------|
| 1  | Зараагийн дэнж хогийн цэг түрж хашаажуулах          | 16           |                |                 | 16                        | 12                   |
| 2  | Спорт заалны шал солих                              |              |                | 55              | 55                        | 1                    |
| 3  | Ундны усны худаг цахимжуулах, засвар үйлчилгээ      |              |                | 51              | 51                        | 2                    |
| 4  | Дунд-Урт голын гүүр засварлах                       |              |                | 45              | 45                        | 2                    |
| 5  | 12 айлын дээвэр засвар, гадна фасат                 |              |                | 35              | 35                        | 5                    |
| 6  | Даргиат 3-р баг камержуулалт хийх                   |              |                | 43              | 43                        | 4                    |
| 7  | Сарлаг багийн цэцэрлэгийн байрны засвар             |              | 14             |                 | 14                        | 13                   |
| 8  | Гамшигаас хамгаалах зардал                          |              |                | 20              | 20                        | 8                    |
| 9  | Соёлын төвийн өргөтгөлийн засвар                    |              |                | 32              | 32                        | 7                    |
| 10 | Нохой муур устгах                                   |              | 12             |                 | 12                        | 14                   |
| 11 | ЗДТГ-ын барилгын засвар                             |              |                | 18              | 18                        | 10                   |
| 12 | Даргиат 3-р багт бод малын тарилгын хашаа барих     |              |                | 35              | 35                        | 6                    |
| 13 | Гуна баг хар үзүүрийн хадлангийн талбай хашаажуулах | 19           |                |                 | 19                        | 9                    |
| 14 | Мал хамгаалах гамшигийн зардал                      |              | 17             |                 | 17                        | 11                   |

|    |                                               |  |  |  |   |  |
|----|-----------------------------------------------|--|--|--|---|--|
| 15 | Наадам, ахмадын баяр гм арга хэмжээний зардал |  |  |  | 0 |  |
|----|-----------------------------------------------|--|--|--|---|--|

### Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гүйцэтгэхдээ:

#### 1. Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ:

| №  | Худалдан авсан бараа ажил үйлчилгээ             | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Гүйцэтгэгч                       | Худалдан авах ажиллагаа |
|----|-------------------------------------------------|--------------|--------------|----------------------------------|-------------------------|
| 1  | Үйлдвэр хороололд тоглоомын талбай              | 26,007.2     | 26,007.2     | ХААН БАГАНА ХХК                  | ХА                      |
| 2  | Зураг төсөв /Дулаан, спорт заал, цэцэрлэг гм/   | 5,000.0      | -            |                                  |                         |
| 3  | Зараагийн дэнж хогийн цэг түрж хашаажуулах      | 10,000.0     | 10,000.0     | Э.Амар                           | ШГБ                     |
| 4  | Спорт заалны шал солих                          | 100,000.0    | 69,989.3     | Өгөөмөр-Уул ХХК                  | НТ                      |
| 5  | Ундны усны худаг цахимжуулах, засвар үйлчилгээ  | 14,000.0     | 14,000.0     | Баялаг говь ХХК                  | ШГБ                     |
| 6  | Дунд-Урт голын гүүр засварлах                   | 7,000.0      | 6,998.0      | Ч.Мэндсайхан                     | ШГБ                     |
| 7  | 12 айлын дээвэр засвар, гадна фасат             | 59,400.0     | 57,210.5     | Хаппи лайнд констракшин ХХК      | ХА                      |
| 8  | Даргиат 3-р баг камержуулалт хийх               | 20,000.0     | 19,987.0     | "Мэдээлэл харилцаа холбоо" ТӨХХК | ШГБ                     |
| 9  | Сарлаг багийн цэцэрлэгийн байрны засвар         | 30,000.0     | 29,897.1     | Хаппи лайнд констракшин ХХК      | ХА                      |
| 10 | Гамшигаас хамгаалах зардал                      | 14,607.1     | 14,607.1     |                                  | ШГБ                     |
| 11 | Соёлын төвийн өргөтгөлийн засвар                | 15,000.0     | 15,000.0     | Т.Пүрэвдорж                      | ШГБ                     |
| 12 | Нохой муур устгах                               | 2,000.0      | 2,000.0      | Б.Наранбат                       | ШГБ                     |
| 13 | ЗДТГ-ын барилгын засвар                         | 100,000.0    | 99,870.5     | Силвер Эделвэйз ХХК              | НТ                      |
| 14 | Даргиат 3-р багт бод малын тарилгын хашаа барих | 9,000.0      | -            |                                  |                         |

|          |                                                     |           |           |          |     |
|----------|-----------------------------------------------------|-----------|-----------|----------|-----|
| 15       | Гуна баг хар үзүүрийн хадлангийн талбай хашаажуулах | 10,000.0  | 10,000.0  | Ж.ГАНХҮҮ | ШГБ |
| 16       | Мал хамгаалах гамшигийн зардал                      | 12,708.3  | 12,708.3  |          | ШГБ |
| 17       | Наадам, ахмадын баяр гм арга хэмжээний зардал       | 20,000.0  | 5,370.5   |          | ШГБ |
| Нийт дүн |                                                     | 454,722.6 | 393,645.5 |          |     |

Санхүүгийн гүйцэтгэл:

- Оны эхний үлдэгдэл 37,566.3 мянган төгрөг
- Санхүүжилт 350,253.3 мянган төгрөг
- Малын хөлийн татвараас 31,708.3 мянган төгрөг
- Бусад орлого 5,370.5 мянган төгрөг
- Гүйцэтгэгч байгууллагад 364,485.1 мянган төгрөг
- Оны эцсийн үлдэгдэл 60,413.3 мянган төгрөг

#### Орон нутгийн хөгжлийн сангийн тайлагнал

1. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 5.1-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайланг ОНХС-ийн мэдээллийн системд оруулаагүй, Шилэн дансны хөрөнгө оруулалт цэсэнд төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулан ажилласан байна.
2. Сумын ИТХ-д 2024 оны ОНХС-ийн гүйцэтгэлийн явцын мэдээлэл хийж, тодотгол батлуулан ажилласан байна.

#### Зургаа. Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хүрээнд суманд хэрэгжих “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг батлан мөрдөж ажилладаг боловч ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт шалгалт хийх талаар төлөвлөгөө, гүйцэтгэл хийгдээгүй байна.

Сумын ИТХ-ын хороод, ажлын хэсгээс орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

#### Долоо. Өмнөх шалгалтын талаар

Төрийн аудитын байгууллагаас 2024 онд хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар 691.6 мянган төгрөгийн акт бичигдсэн байна. Тус актыг бүрэн барагдуулсан байна.

#### Найм. Шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар

Шалгалтаар илэрсэн зөрчилгүй. Акт, албан шаардлага бичигдээгүй.

**Ес. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар өгсөн зөвлөмж**

1. Сангийн сайдын 86-р тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах
2. ЗДТГ-ын дотоод хяналтын ажлын хэсгийн төлөвлөгөөнд ОНХС-аар хийсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд хяналт шалгалт хийх ажлыг тусгаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах.
3. Зараагийн дэнжийн хог түрэх, хашаажуулах ажилд урьдчилгаа санхүүжилт 4.0 сая төгрөгийг өгсөн байна. Ажил дуусаагүй, хүлээж аваагүй тул байгууллагаас авах авлагаар тусгах.

**Арав. Шалгалтаар өгсөн дүгнэлт**

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын тушаалаар баталсан төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд: Баянцогт сумын ОНХС нь 69%-тай "Шаардлага сайн хангасан" гэж дүгнэгдлээ.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ С.НАМШИР

ТАНИЛЦСАН:

БАЯНЦОГТ СУМЫН

ЗАСАГ ДАРГА Б.БАТТУШИГ  
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА Б.ДОЛГОРСҮРЭН



**Баянцогт сумын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн үйл  
ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийсэн үзүүлэлт**

| №                                                                         | Эрсдэлийн үнэлгээ өгөх үзүүлэлт                                                                                                                                                               | Батлагдсан оноо                |                                |                            | Авсан<br>оноо |
|---------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|----------------------------|---------------|
|                                                                           |                                                                                                                                                                                               | Шаардлага сайн<br>хангасан (5) | Шаардлага дунд<br>хангасан (3) | Шаардлага<br>хангаагүй (0) |               |
| Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал |                                                                                                                                                                                               |                                |                                |                            |               |
| 1                                                                         | 3.2.1.Ажлын хэсгийн боловсруулсан тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг санал тус бүрээр хэлэлцэн батлах, нийтэд мэдээлэх;    | 5                              |                                |                            | 5             |
| 2                                                                         | 3.2.2.Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;                                                                |                                | 3                              |                            | 3             |
| Сумын засаг даргын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал                        |                                                                                                                                                                                               |                                |                                |                            |               |
| 3                                                                         | 3.4.3.Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;                                                                                              |                                | 3                              |                            | 3             |
| 4                                                                         | 3.4.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих; | 5                              |                                |                            | 5             |
| 5                                                                         | 3.4.5.ОНХС-ийн УМС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах;                                           | 5                              |                                |                            | 5             |
| 6                                                                         | 3.4.6.ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэх.                                                                                                                   |                                | 3                              |                            | 3             |
| Багийн засаг даргын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал                       |                                                                                                                                                                                               |                                |                                |                            |               |
| 7                                                                         | 3.5.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулах;                                                          | 5                              |                                |                            | 5             |
| 8                                                                         | 3.5.3.Иргэдээс авсан ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын урьдчилсан жагсаалтыг бэлтгэж иргэдийн Нийтийн Хурал/цаашид ИНХ гэх/-д хүргүүлэх;                     | 5                              |                                |                            | 5             |
| Бусад чиг үүргийн хэрэгжилтийн байдал.                                    |                                                                                                                                                                                               |                                |                                |                            |               |
| 9                                                                         | 4.3.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;                                   | 5                              |                                |                            | 5             |
| 10                                                                        | 4.5.Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ                  | 5                              |                                |                            | 5             |

|                 |                                                                                                                                                                                                                                                                         |                                              |   |   |    |
|-----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|---|---|----|
| 11              | 6.1.Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна. | 5                                            |   |   | 5  |
| 12              | 6.4.1.Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх;                                                                                                                                 | 5                                            |   |   | 5  |
| 13              | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.                                                                                                                                                                                              | 5                                            |   |   | 5  |
| 14              | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг данс бүртгэлд тусгасан эсэх.                                                                                                                                                                                     | 5                                            |   |   | 5  |
| 15              | Өмнөх хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал                                                                                                                                                                                                            | 5                                            |   |   | 5  |
| ДҮН             |                                                                                                                                                                                                                                                                         | 60                                           | 9 | 0 | 69 |
| Үнэлгээ         |                                                                                                                                                                                                                                                                         | Шаардлага сайн хангасан                      |   |   |    |
| БАТАЛГААЖУУЛАЛТ |                                                                                                                                                                                                                                                                         |                                              |   |   |    |
| 1               | Хяналт шалгалт хийсэн албан тушаалтны овог нэр                                                                                                                                                                                                                          | Хүлээн зөвшөөрсөн албан тушаалтан            |   |   |    |
| 2               | Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч..... /С.Намшир/                                                                                                                                                                                                              | Засаг дарга..... /Б.Баттүшиг/                |   |   |    |
| 3               |                                                                                                                                                                                                                                                                         | Санхүүгийн албаны дарга..... /Б.Долгорсүрэн/ |   |   |    |

60-75 оноо Шаардлага сайн хангасан  
50-60 оноо Шаардлага дунд хангасан  
50- доош оноо Шаардлага хангаагүй